



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/45/НА-СТА-ТШЗ

<p>Цахим <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:lkhagvadulamyo@audit.gov.mn">lkhagvadulamyo@audit.gov.mn</a> Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:tegshikhamb@audit.gov.mn">tegshikhamb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 01. 23 № 114  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН  
СОНГИНОХАЙРХАН  
ДҮҮРГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН  
ШУУД ЗАХИРАГЧ Н.ХӨХӨӨ  
ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны бүрдэл дутуу болон бүрдэлгүй баримтаар 86.9 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн.

Боловсролын системд бүртгэлтэй хүүхдийг Хүүхэд харах үйлчилгээний төвийн хүүхдийн ирц давхардуулан 7.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Азийн хөгжлийн банкны санхүүжилт хөрөнгө оруулалтаар хийгдсэн, СХД-ийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн дагуу "Түр хамгаалах байр"-ыг хүлээн авч, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх боломж нээгдсэн байна.

Тайлант онд бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж, орон тоо 19 нэмэгдэж, нийт 42 орон тоо батлагдсанаас 11 орон дутуу ажилласан.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Тус хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 5 хоногоор хоцроон 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн. Жилийн эцэст нягтлан бодогч өөрчлөгдсөнөөс шалтгаалан алдаатай санхүүгийн тайланг олон удаа ирүүлсэн нь аудит хийхэд хүндрэлтэй байсан.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>68,917,001.00</u></b>	<b><u>102,015,472.95</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	58,362,800.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	58,362,800.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	58,362,800.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	10,554,201.00	102,015,472.95
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,554,201.00	102,015,472.95
35410	Бичиг хэргийн материал	3,130,439.00	1,125,192.00
35420	Аж ахуйн материал	332,950.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	309,800.00	4,966,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,781,012.00	95,924,280.95
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>51,047,732.72</u></b>	<b><u>271,551,830.16</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	51,047,732.72	271,551,830.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	38,628,632.65	259,136,580.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-8,651,000.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,724,091.11	130,615,873.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,964,694.14	-49,940,810.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,149,481.10	189,111,484.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,280,245.42	-26,998,967.46
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,419,100.07	12,415,250.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-766,149.93	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,115,250.00	15,115,250.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,700,000.00	-2,700,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>119,964,733.72</u></b>	<b><u>373,567,303.11</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>99,102,424.02</u></b>	<b><u>373,567,303.11</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	99,102,424.02	373,567,303.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,415,250.00	12,415,250.00
51101	Өмч: - төрийн	12,415,250.00	12,415,250.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	86,687,174.02	361,152,053.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-12,403,850.00	-70,766,650.00

51220	Тайлант үеийн үр дүн	99,091,024.02	431,918,703.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>119,964,733.72</u></b>	<b><u>373,567,303.11</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>808,863,100.00</b>	<b>1,684,713,237.67</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>239,085.00</b>	<b>329,294,379.67</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	239,085.00	329,294,379.67
120005	Түрээсийн орлого		
120006	Газрын тосны орлого		
120009	Бусад орлого	239,085.00	504,279.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>808,624,015.00</b>	<b>1,355,418,858.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	334,863,200.00	493,978,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	334,863,200.00	493,978,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	473,760,815.00	861,440,358.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	467,260,815.00	857,103,658.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,500,000.00	4,336,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>862,948,606.01</b>	<b>1,351,885,558.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>862,948,606.01</b>	<b>1,351,885,558.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	806,003,748.11	1,085,456,615.68
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	242,646,466.30	365,958,954.44
210101	Үндсэн цалин	194,697,369.87	230,387,348.23
210102	Нэмэгдэл	14,588,476.24	52,253,972.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,252,191.24	42,906,520.34
210104	Урамшуулал	2,108,428.95	29,902,855.53
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,508,258.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,090,347.90	43,874,286.90
210201	Тэтгэврийн даатгал	18,066,579.68	34,964,093.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,221,874.63	2,491,260.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,543,202.29	1,864,033.92
210204	Ажилгүйдлийн даатгал	381,376.13	409,519.05
210205	Эрүүл мэндийн даатгал	3,877,315.17	4,145,379.83

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,250,000.00	2,931,285.63
210301	Гэрэл, цахилгаан	1,333,400.00	1,896,501.63
210303	Цэвэр, бохир ус	916,600.00	1,034,784.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,355,075.60	10,106,599.01
210401	Бичиг хэрэг	3,253,905.00	4,660,762.44
210402	Тээвэр, шатахуун	12,488,600.00	1,445,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,040.60	2,176,686.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	690,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,619,530.00	1,134,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	110,000.00
210604	Урсгал засвар	00.00	110,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	439,721,918.00	637,319,413.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,237,618.00	635,198,403.62
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	473,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,800.00	657,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	448,000.00
210807	Газрын төлбөр	1,390,500.00	543,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	76,939,940.31	25,156,076.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,362,800.00	6,376,138.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,000.00	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,887,140.31	18,479,938.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,944,857.90	266,428,942.90
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	965,000.00	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	965,000.00	1,150,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	55,979,857.90	265,278,942.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,979,857.90	265,278,942.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-54,085,506.01</b>	<b>332,827,679.09</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-54,085,506.01</b>	<b>332,827,679.09</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>808,863,100.00</b>	<b>1,355,418,858.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>808,624,015.00</b>	<b>1,355,418,858.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	334,863,200.00	493,978,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	334,863,200.00	493,978,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	473,760,815.00	861,440,358.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	467,260,815.00	857,103,658.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,500,000.00	4,336,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>750,080,243.10</b>	<b>1,353,972,358.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>750,080,243.10</b>	<b>1,353,972,358.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>749,115,243.10</b>	<b>1,087,543,415.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	225,459,497.93	384,018,265.14
210101	Үндсэн цалин	177,510,401.50	248,446,658.93
210102	Нэмэгдэл	14,588,476.24	52,253,972.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,252,191.24	42,906,520.34
210104	Урамшуулал	2,108,428.95	29,902,855.53
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,508,258.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,218,005.57	43,874,286.90
210201	Тэтгэврийн даатгал	17,194,237.35	34,964,093.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,221,874.63	2,491,260.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,543,202.29	1,864,033.92
210204	Ажилгүйдлийн даатгал	381,376.13	409,519.05
210205	Эрүүл мэндийн даатгал	3,877,315.17	4,145,379.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,250,000.00	2,931,285.63
210301	Гэрэл, цахилгаан	1,333,400.00	1,896,501.63
210303	Цэвэр, бохир ус	916,600.00	1,034,784.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,106,540.60	19,800,203.01
210401	Бичиг хэрэг	3,815,200.00	3,352,990.44
210402	Тээвэр, шатахуун	6,677,600.00	9,372,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,040.60	2,676,661.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	690,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,700.00	3,707,651.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	32,481,008.42

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	656,319.42
210502	Хоол, хүнс	00.00	16,988,889.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	14,835,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>482,391,199.00</b>	<b>558,498,366.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,906,899.00	556,107,856.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	473,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,800.00	926,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	448,000.00
210807	Газрын төлбөр	1,390,500.00	543,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>690,000.00</b>	<b>45,940,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	45,640,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,000.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>965,000.00</b>	<b>266,428,942.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>965,000.00</b>	<b>1,150,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	965,000.00	1,150,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>265,278,942.90</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	265,278,942.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>58,782,856.90</u></b>	<b><u>1,446,500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>1,446,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>1,446,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>1,446,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,446,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b><u>-1,446,500.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>58,782,856.90</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>00.00</b>	<b>140,772,680.03</b>	<b>153,187,930.03</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-54,085,506.01	-54,085,506.01
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>00.00</b>	<b>86,687,174.02</b>	<b>99,102,424.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-58,362,800.00	-58,362,800.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>00.00</b>	<b>28,324,374.02</b>	<b>40,739,624.02</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	332,827,679.09	332,827,679.09
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>00.00</b>	<b>361,152,053.11</b>	<b>373,567,303.11</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>493,978,500.00</b>	<b>321,314,731.16</b>	<b>172,663,768.84</b>	<b>65.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>493,978,500.00</b>	<b>321,314,731.16</b>	<b>172,663,768.84</b>	<b>65.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>493,032,600.00</b>	<b>320,464,731.16</b>	<b>172,567,868.84</b>	<b>65.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>414,375,500.00</b>	<b>280,407,893.83</b>	<b>133,967,606.17</b>	<b>67.7</b>

210101	Үндсэн цалин	252,314,200.00	195,754,077.32	-56,560,122.68	77.6
210102	Нэмэгдэл	104,585,700.00	30,586,613.70	-73,999,086.30	29.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,957,000.00	32,250,416.78	-1,706,583.22	95.0
210104	Урамшуулал	23,518,600.00	21,816,786.03	-1,701,813.97	92.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,797,000.00</b>	<b>32,001,997.01</b>	<b>-19,795,002.99</b>	<b>61.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,221,900.00	23,091,803.85	-12,130,096.15	65.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,143,800.00	2,491,260.36	-1,652,539.64	60.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,315,000.00	1,864,033.92	-1,450,966.08	56.2
210204	Ажилгүйдлийн даатгал	828,800.00	409,519.05	-419,280.95	49.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,287,500.00	4,145,379.83	-4,142,120.17	50.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,708,400.00</b>	<b>00.00</b>	<b>-14,708,400.00</b>	<b>-</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,568,900.00	00.00	-9,568,900.00	-
210303	Цэвэр, бохир ус	5,139,500.00	00.00	-5,139,500.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,274,000.00</b>	<b>7,804,840.32</b>	<b>-469,159.68</b>	<b>94.3</b>
210401	Бичиг хэрэг	1,869,800.00	1,867,840.44	-1,959.56	99.9
210402	Тээвэр, шатахуун	3,272,900.00	3,272,900.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,869,800.00	1,869,799.88	-0.12	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	467,200.00	00.00	-467,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	794,300.00	794,300.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,159,700.00</b>	<b>00.00</b>	<b>-3,159,700.00</b>	<b>-</b>
210803	Даатгалын үйлчилгээ	74,500.00	00.00	-74,500.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	00.00	-98,000.00	-

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,500.00	00.00	-24,500.00	-
210807	Газрын төлбөр	2,962,700.00	00.00	-2,962,700.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>718000.00</b>	<b>250000.00</b>	<b>-468,000.00</b>	<b>34.8</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	718,000.00	250,000.00	-468,000.00	34.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>945,900.00</b>	<b>945,900.00</b>	<b>945,900.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>945,900.00</b>	<b>945,900.00</b>	<b>945,900.00</b>	<b>100.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	945,900.00	945,900.00	945,900.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	00.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>493,978,500.00</b>	<b>321,314,731.16</b>	<b>172,663,768.84</b>	<b>65.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>493,978,500.00</b>	<b>321,314,731.16</b>	<b>172,663,768.84</b>	<b>65.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	493,978,500.00	321,314,731.16	172,663,768.84	65.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>42.00</b>	<b>42.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>768,825,183.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>768,825,183.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>768,525,183.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>103,610,371.31</b>

210101	Үндсэн цалин	52,692,581.61
210102	Нэмэгдэл	21,667,358.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,656,103.56
210104	Урамшуулал	8,086,069.50
210105	Гэрээт ажлын хөлс	10,508,258.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,872,289.89</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,872,289.89
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,931,285.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,896,501.63
210303	Цэвэр, бохир ус	1,034,784.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,995,362.69</b>
210401	Бичиг хэрэг	1,485,150.00
210402	Тээвэр, шатахуун	6,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	806,861.69
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,913,351.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,481,008.42</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	656,319.42
210502	Хоол, хүнс	16,988,889.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,835,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,446,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,446,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>558,498,366.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,107,856.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,010.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	926,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	448,000.00
210807	Газрын төлбөр	543,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,690,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,640,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>768,825,183.94</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>768,825,183.94</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	764,488,483.94
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,336,700.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 764,975.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнг 54,085.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд улсын болон орон нутгийн санхүүжилтийн дүнг төрийн сангийн хуулгатай тулган үзэхэд 88,853.9 мянган төгрөгөөр зөрүүлэн тайлагнасан.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөний дүнг 54,082.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улс, орон нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийн дүнг зөрүүлэн 88,853.9 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 265,279.0 мянган төгрөгийг олгосон санхүүжилтээс буруулж тайлагнаагүй, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлаар тайлагнасан.
- Тооцсон цалин, цалингаас суутгасан суутгалуудыг ерөнхий журналын бичилт, авлага өглөгийн тодруулгатай тулган шалгахад цалин хөлс дансны бичилтүүд 213,820.9 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн.

Эдгээр нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “Толилуулга”, “Иж бүрэн”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 115,753.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 31,396.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 84,357.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

### **3.1 Албан шаардлага**

Илрүүлэлт-1: Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн тодорхой тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй 29,959.6 мянган төгрөгийн гүйлгээг зардалд тусгасан нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” заалтыг хэрэгжүүлээгүй, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Иж бүрэн байх” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

Илрүүлэлт-2: НДШ-ийг 564.3 мянга, ХХОАТ-ыг 872.3 мянга, нийт 1,436.6 мянган төгрөгөөр илүү төлж авлагыг санхүүгийн тайланд тайлагнаагүй нь цалин хөлс зөрүүтэй бодогдож, татвар шимтгэлийн өглөг дутуу суутгагдаж, тайлангийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх үр дагавар бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “*Үнэн зөв байх*”, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ХХОАТ-ын хуулийн холбогдох заалтууд хэрэгжээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

Илрүүлэлт-3: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас таван сая төгрөгөөс дээших орлогын 894,838.2 мянган төгрөгийн 18 гүйлгээ, зарлагын 150,314.1 мянган төгрөгийн 22 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1 “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг ханган, мэдээллийг хугацаандаа ил тод бүрэн тусгаж байхыг аудитаар зөвлөмж өглөө.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт-1: Зарим төсөл хөтөлбөр арга хэмжээнд төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар 56,984.2 мянган төгрөгийн гүйлгээ хийж зардалд нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт хэрэгжээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, хөтөлбөр арга хэмжээнд төсөв баталж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Илрүүлэлт-2: Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн ирцийг боловсролын системд дэх бүртгэлтэй тулгахад давхардуулан хүүхэд бүртгэж 7,664.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон. Энэ нь Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоол "Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам"-ын 1.6. "Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхэд нь цэцэрлэгт давхар хамрагдаагүй буюу боловсролын салбарын мэдээллийн систем"-д бүртгэгдээгүй байна" заалт хэрэгжээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зарцуулалт болон хүүхэд харах үйлчилгээний ирц бүртгэлд хяналт тавьж, журмыг хэрэгжүүлж ажиллах.

#### **2. Цалин хөлсний холбоотой асуудал**

Илрүүлэлт-1: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг НДШ-ийн тайланд 18,669.7 мянган төгрөгөөр дутуу, ХХОАТ-ын тайланд 1,039.0 мянган мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого алдагдаж тайлан журналын бичилт, тайлан тодруулгууд алдаатай илэрхийлэгдэх үр дагавар бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалт, 5 дугаар зүйлийн 5.1-т "Үнэн зөв байх" заалт хэрэгжээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсний ноогдолт, суутган тооцоололтой холбоотой ерөнхий журналын бичилт, тайлан тодруулгыг сангийн сайдын баталсан дүрэм журам, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлж байх.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу-лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнг дутуу тайлагнасан.	1	54.1			1	54.1	1	54.1				
Мөнгөн гүйлгээний тайланд улсын болон орон нутгийн санхүүжилтийн дүнг төрийн сангийн хуулгатай тулган үзэхэд зөрүүлэн тайлагнасан.	1	88.8			1	88.8	1	88.8				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөний дүнг дутуу тайлагнасан.	1	54.1			1	54.1	1	54.1				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улс, орон нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийн дүнг зөрүүлэн алдаатай тайлагнасан.	1	88.8			1	88.8	1	88.8				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг санхүүжилтээс буруулж тайлагнаагүй, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлаар тайлагнасан.	1	265.4			1	265.4	1	265.4				
Тооцсон цалин, цалингаас суутгасан суутгалуудыг ерөнхий журналын бичилт, авлага өглөгийн тодруулгатай тулган шалгахад цалин хөлс дансны бичилтүүд алдаатай.	1	213.8			1	213.8	1	213.8				

Дүн	6	765.0		6	765.0	6	765.0				
-----	---	-------	--	---	-------	---	-------	--	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалт тодорхой тайлангүй, хэрэгжсэн гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардалд тусгасан	1	30.0			1	30.0						
Цалингаас илүү тооцсон НДШ, ХХОАТ-ын авлагыг санхүүгийн тайланд тайлагнаагүй, тооцоо нийлсэн актаас зөрүүтэй.	1	1.4			1	1.4						
Зарим төсөл хөтөлбөр арга хэмжээнд төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж зардалд тусгасан.	1	57.0					1	57.0				
Боловсролын системд бүртгэлтэй хүүхдийг Хүүхэд харах үйлчилгээний төвийн хүүхдийн ирц давхардуулан санхүүжилт олгосон	1	7.7					1	7.7				
Тооцсон цалинг, НДШ-ийн тайлан болон ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан.	1	19.7					1	19.7				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>115.8</b>			<b>2</b>	<b>31.4</b>	<b>3</b>	<b>84.4</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

